



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Монгол улсын "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8.8, Ариун цэврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ Нь:

1. "Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хүүхдийн байгууллагын ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журам"-ыг нэгдүгээр, "Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дэвтэр"-ийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг батлагдсан журмын дагуу хийж гүйцэтгэхийг Нийслэл, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг, лаборатори бүхий Сумын эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлгүүдийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар) нарт тус тус даалгасугай.



Эрүүл мэндийн сайдын 2013 оны
06 сарын 10 өдрийн ~~наа~~ тоот тушаалын
нэгдүгээр хавсралт

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАНД ТАВИХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ШААРДЛАГА, ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хүүхдийн байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд /цаашид "урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ" гэх/ хамруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг нийслэлд дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, орон нутагт Бусийн оношлогоо эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг, лаборатори бүхий сумын эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлгүүдэд хийж гүйцэтгэнэ.

1.3. Тухайн эрүүл мэндийн байгууллагад мөрдөж байгаа үйлчилгээний төлбөрийг мөрднө.

Хоёр. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний төрөл, хамрах хүрээ

2.1. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ нь дараах үзлэг шинжилгээнээс бүрдэнэ.

а/Үзлэг:

- 2.1.1 Сүрьеэ
- 2.1.2 Арьсны халдварт өвчинүүд

б/Шинжилгээнд:

- 2.1.3 Нян тээгч илрүүлэх
- 2.1.4 Хамар залгиурын арчдасын шинжилгээ
- 2.1.5 Цагаан хорхой илрүүлэх
- 2.1.6 Флюорографийн зураг

2.2. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд дараах ажил, үйлчилгээ эрхлэгч этгээд хамрагдана.

2.2.1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биөчлэн харьцдаг ажилтан, ажиллагсад;

2.2.2. Төрийн болон хувийн эзэмшлийн усан хангамжийн байгууллагын ус түгээгч, инженер, техникч, усны машины жолооч;

2.2.3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон хүүхдийн зуслан, асрамж, халамжийн газрын багш, туслах багш, нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн багш нар.

Гурав. Ажилтанд тавигдах шаардлага

3.1. Журмын 2.2-д заасан ажил үйлчилгээг эрхлэхийн өмнө болон цаашид 6 сар тутамд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдана.

3.2. Халдварт өвчинөөр өвчилсөн буюу өвчтөнтэй хавьтал болсон тохиолдолд тухай бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдана.

3.3. Ажилтан урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дэвтэрт бичигдсэн санамж зөвлөмжтэй танилцсан гарын үсэг зурж, санамжийг мөрдөж ажиллана.

Дөрөв. Ажил олгогчид тавигдах шаардлага

4.1. Ажилтан, ажиллагсадыг журмын 3.1-т заасан хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ хийж урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулна.

4.2. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн зэрэг гарсан ажилтнуудыг эмчилж, эрүүлжүүлэх, хөдөлмөр зохицуулалт хийх ажлыг Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

4.3. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байдал, баталгаажуулалтанд хяналт тавьж ажиллана.

Тав. Эрүүл мэндийн байгууллагад тавигдах шаардлага

5.1. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг холбогдох стандарт арга, аргачлалын дагуу үнэн зөв, бүрэн хийнэ.

5.2. Үзлэг, шинжилгээний үр дүнг эмч болон эмнэлгийн удирдлага эсхүл эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Эрх бүхий албан тушаалтыг тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тушаалаар томилж, гарын үсгийн тайлал болон тэмдэгийн загварыг баталгаажуулсан байна.

5.3. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн “эерэг” гарсан иргэн, ажилтныг эмчилж, эрүүлжүүлэх арга хэмжээг авна.

5.4. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх зөвшөөрлийг /итгэмжлэл/-ийг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан байна.

5.5. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийсэн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Халдварт өвчин судлалын үндэсний төв болон дээд шатны урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний асуудал эрхэлсэн байгууллагад мэдээлнэ.

5.6. Эрүүл мэндийн дэвтрийг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, ашиглана.

Зургаа. Хориглох зүйл

6.1. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ бүрэн хийгдээгүй, лабораторийн шинжилгээний дугаар бичигдээгүй тохиолдолд баталгаажуулах;

6.2. Эрүүл мэндийн дэвтрийг хуурамчаар үйлдэх, засварлах;

6.3. Журамд зааснаас бусад улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад үзлэг, шинжилгээ хийлгэх;

6.4. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдаагүй хүнийг ажиллуулахыг хориглоно.

Дөлөө. Бусад

7.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----оо----

A. Гадна тал

/Эмнэлгийн нэр/

Урьдчилан сэргийлэх үзлэг,
шинжилгээний дэвтэр

Санамж

1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захирагааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу ажил үйлчилгээ эрхлэхийн өмнө болон цаашид б 6 сар тутамд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдана.
2. Халдварт өвчнөөр өвчилсөн буюу өвчтөнтэй хавьтал болсон тохиолдолд тухай бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдана.
3. Байгууллагын дотоод хяналт хариуцсан ажилтан болон бусад хяналт тавих эрх бүхий этгээдэд дэвтрүйг шалгуулна.
4. Дэвтрүйг хуурамчаар үйлдэх, засварлах, бусдад шилжүүлэхийг хориглоно.
5. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний бүрдэл дутуу, лабораторийн шинжилгээний дугааргүй, эмч, албан тушаалтны гарын үсэг, тэмдэггүй, бичигдсэн зүйл засвартай бол хүчингүйд тооцно.

Танилцсан: /
гарын үсэг

нэр

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
06. сарын 10 өдрийн 6 тоот тушаалын
хөөрдугаар хавсралт

B. Нуур хуудас

Дугаар.....

Байгууллагын нэр

зураг

Овог.....

Нэр.....

Эрхлэх ажил

Ажилд орсон он, сар, өдөр.....

Дэвтэр олгосон он, сар, өдөр.....

/Биеийн зураг, тамга тэмдэггүй бол
хүчингүй/

Он.....

Сүрьеэ: /Флюорографийн дугаар/.....

/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Арсын халдварт өвчнүүд: /шинжилгээний
дугаар/.....

/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Нян тээгч: /шинжилгээний дугаар/.....

/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Хамар залгиурын арчдас: /шинжилгээний дугаар/.....

/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Цагаан хорхой: /шинжилгээний дугаар/.....

/Эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг/

Баталгаажуулсан:

Албан тушаалтны нэр, гарын үсэг,
тэмдэг.....